

**ЁС ЗҮЙ, САХИЛГА ХАРИУЦЛАГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2023 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 2-3

1.Байнгын хорооны даргыг сонгох тухай 2-3

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы
Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны
11 дүгээр сарын 28-ны өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын гишүүн Х.Баделхан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 10 гишүүнээс 6 гишүүн хүрэлцэн ирж, 60.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 21 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.

Томилолттой: Б.Бейсен, С.Бямбацогт, Л.Энх-Амгалан;
Чөлөөтэй: Б.Энхбаяр.

Нэг. Байнгын хорооны даргыг сонгох тухай

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Х.Энэбиш, референт Ц.Энх-Амгалан байлцав.

Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд Улсын Их Хурлын гишүүн Д.Баттөмөрийг Байнгын хорооны даргад нэр дэвшүүлж байгаа талаар танилцуулав.

Танилцуулга болон нэр дэвшигчтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Х.Баделхан: Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөрийг сонгохыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 4
Татгалзсан: 2
Бүгд: 6
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Баярсайхан Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 10 цаг 26 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 05 минут үргэлжилж, ирвэл зохих 10 гишүүнээс 6 гишүүн хүрэлцэн ирж, 60.0 хувийн ирцтэйгээр 10 цаг 26 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЁС ЗҮЙ, САХИЛГА ХАРИУЦЛАГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Б.БАТТӨМӨР

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Үндсэн хууль” танхим
10 цаг 21 минут.

ЁС ЗҮЙ, САХИЛГА ХАРИУЦЛАГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Х.Баделхан: 2023 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье. Хуралдаанд ирсэн гишүүдийг танилцуулъя. Баттөмөр гишүүн ирсэн, Адъяаа гишүүн ирсэн, Баделхан гишүүн ирсэн, Бат-Эрдэнэ гишүүн ирсэн, Баярсайхан гишүүн ирсэн, Н.Энхболд гишүүн ирсэн байна. Ингээд хурлын ирц 60 хувьтай байна. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 11.6-д заасны дагуу хуралдааны ирцийг гишүүн бүрээр танилцууллаа.

Ингээд хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Байнгын хорооны даргыг сонгох тухай асуудлыг хэлэлцэнэ. Өөр хэлэлцэх асуудлын талаар саналтай гишүүд байна уу? Алга байна. Хэлэлцэх асуудалд оръё. Байнгын хорооны даргыг Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх тухай асуудлыг Энхболд гишүүн танилцуулна Бүлгийн саналыг.

Н.Энхболд: Байнгын хорооны гишүүддээ энэ өдрийн мэнд хүргэе. Монгол Улсын Их Хурлын Ёс зүй, сахилга бат, хариуцлагын байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх ажлыг танилцуулъя. Их Хурал дахь Ардын намын бүлэг дээр асуудлыг хэлэлцээд нэрээ дэвшүүлэхийг санал болгосон гишүүдийн асуудлыг авч хэлэлцээд, Монгол Улсын Их Хурлын гишүүн Багаагийн Баттөмөрийг Монгол Улсын Их Хурлын Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны даргаар улируулан сонгох асуудлыг шийдвэрлэсэн.

Ингээд би Баттөмөр нарын товч намтрыг танилцуулъя. 1979 онд Хөдөө аж ахуйн их сургуулийг инженер механикийн мэргэжлээр төгссөн. 1991 онд Оросын Холбооны Улсын Москва хотын Нийгэм, улс төрийн дээд сургуулийг эдийн засагч, улс төр судлаач мэргэжлээр төгссөн. 2001 онд Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн дээд сургуулийг эрх зүйч мэргэжлээр тус тус төгссөн. 2003 онд Эдийн засгийн ухааны доктор PHD, 2008 онд Эдийн засгийн шинжлэх ухааны доктор, science doctor докторын зэрэг тус тус хамгаалсан. 80-86 онд 1980-1986 онд Ой модны аж үйлдвэрийн яаманд мэргэжилтэн, хэлтсийн дарга, 86-аас 89 онд Хөнгөн үйлдвэрийн яаманд хэлтсийн дарга, 2-оос 2000-2008 онд Улсын гаалийн ерөнхий газрын дэд дарга, дарга, 2011-ээс 13 онд Монголын Үндэсний татварын ерөнхий газрын дарга, 2016-аас 20 онд Монгол Улсын Их Хурлын гишүүн, 2020 оноос хойш мөн дахин сонгогдож, Монгол Улсын Их Хурлын гишүүнээр ажиллаж байгаа. 20-оос 22 онд Монгол Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны даргаар, 2022 оноос Монгол Улсын Их Хурлын Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны даргаар тус тус ажиллаж байгаа. Ингээд МАН-ын бүлгээс Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны даргад Багаагийн Баттөмөрийн нэрийг дэвшүүлж байна. Танилцуулж дууслаа. Баярлалаа.

Х.Баделхан: Энхболд гишүүнд баярлалаа. Бүлгийн даргаас болон нэр дэвшигчээс асуух асуулттай гишүүн байна уу? Асуулт байхгүй байна. Үг хэлэх хүн байна уу? Алга байна. Тэгвэл санал хураалт явуулна. Ингээд намын бүлгээс нэр дэвшүүлсний дагуу Багаагийн Баттөмөрийг Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны даргаар сонгоё гэсэн гишүүд санал өгнө үү? Санал хураалт. Өгнө, өгнө шүү дээ. 6 хүн санал оролцож, 4 хүн дэмжиж 66,7 хувийн саналаар санал дэмжигдлээ. Баярлалаа. Одоо энэ Байнгын хорооны санал,

дүгнэлтийг чуулган дээр Баярсайхан
гишүүн танилцуулна.

Өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх
асуудал дууссан тул хурал хаасныг
мэдэгдье.

Баярлалаа та бүхэндээ.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ Д.УЯНГА

